

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/194/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: [ariuntuyab@audit.gov.mn](mailto:ariuntuyab@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/242  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.АНХТУЯА ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан,
2. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй,
3. Төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн 31,944.0 мянган төгрөгийн 7 гүйлгээг хийсэн нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй,
4. Шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаараас авсан худалдан авалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулалгүйгээр шууд худалдан авсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэгт "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.", Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын холбогдох заалтыг тус тус зөрчсөн, Сангийн сайдын 2023

оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллын тайлбарыг мөрдөөгүй, "Иж бүрэн байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Эдгээр зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 16,261.5 мянган төгрөгөөр давсан байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Ханх сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 231,859.2 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 198,382.1 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илрүүлж, 166,438.1 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 31,944.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Ханх сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 95.1 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>359,687,932.18</b>	<b>315,813,553.14</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	49,888,277.71	20,500.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	49,888,277.71	20,500.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	49,888,277.71	20,500.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	247,521,952.93	233,344,176.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,485,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	247,521,952.93	231,859,176.45
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	62,277,701.54	82,448,876.69
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	20,434,303.14	29,904,241.19
35130	Эм боох материал	20,434,303.14	29,904,241.19
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,843,398.40	52,544,635.50
35410	Бичиг хэргийн материал	603,800.00	4,075,600.00
35420	Аж ахуйн материал	28,637,918.00	33,525,135.50
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	6,600,006.40	6,621,900.00
35450	Барилгын засварын материал	00.00	2,953,500.00
35460	Хүнсний материал	4,001,674.00	3,368,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>667,086,421.52</b>	<b>674,765,294.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	667,086,421.52	674,765,294.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	639,094,814.36	645,683,294.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	256,524,340.00	256,524,340.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,461,782.11	-88,933,396.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	326,229,366.47	326,229,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,068,035.12	-106,760,122.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	304,132,023.41	412,909,137.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,270,956.52	-194,367,344.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,576,600.00	59,920,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,566,741.77	-19,839,285.64
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	27,991,607.16	29,082,000.00
39301	Програм хангамж	15,000,000.00	15,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,000,000.00	-15,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,082,000.00	29,082,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,090,392.84	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,026,774,353.70</b>	<b>990,578,847.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>8,060,576.55</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	8,060,576.55
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	8,060,576.55
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	8,040,076.55
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	20,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	20,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,026,774,353.70</b>	<b>982,518,271.29</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,026,774,353.70	982,518,271.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	288,330,820.00	288,330,820.00
51101	Өмч: - төрийн	288,330,820.00	288,330,820.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	614,388,554.48	570,132,472.07
51210	Өмнөх үеийн үр дүн	614,388,554.48	615,478,947.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-45,346,475.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,054,979.22	124,054,979.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,026,774,353.70</b>	<b>990,578,847.84</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,510,411,841.67</b>	<b>1,310,111,066.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>403,729,583.45</b>	<b>154,731,927.75</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	403,729,583.45	154,731,927.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	403,729,583.45	154,731,927.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,332,000.00	56,519,355.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	348,178,426.47	82,802,114.20
120005	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	22,219,156.98	15,410,458.07
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,106,682,258.22</b>	<b>1,155,379,138.50</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	26,820,000.00	34,473,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,820,000.00	34,473,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,079,862,258.22	1,120,905,838.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,079,862,258.22	1,120,905,838.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>980,159,296.29</b>	<b>1,355,457,541.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>980,159,296.29</b>	<b>1,355,457,541.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	948,783,278.14	1,298,065,953.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	585,402,511.68	765,926,738.96
210101	Үндсэн цалин	347,847,167.82	457,270,642.75
210102	Нэмэгдэл	175,435,283.86	240,866,356.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,600,000.00	26,745,000.00
210104	Урамшуулал	48,520,060.00	41,044,740.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	70,582,441.13	95,360,566.11
210201	Тэтгэврийн даатгал	47,531,929.65	66,539,159.45
210202	Тэтгэмжийн даатгал	5,849,793.55	7,697,891.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,224,267.80	4,190,351.20
210204	Ажилгүйдлийн даатгал	2,868,032.73	3,378,322.46
210205	Эрүүл мэндийн даатгал	11,108,417.40	13,554,841.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,075,981.85	25,419,274.60
210301	Гэрэл, цахилгаан	1,855,981.85	2,094,274.60
210302	Түлш, халаалт	11,720,000.00	21,525,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	74,452,074.49	110,571,572.78
210401	Бичиг хэрэг	5,210,800.00	12,410,620.00
210402	Тээвэр, шатахуун	40,220,814.49	43,658,904.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,070,000.00	1,893,591.91
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,833,700.00	17,469,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,116,760.00	32,242,580.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,896,776.87
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	100,566,632.45	77,924,720.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	81,051,101.45	59,997,503.17
210502	Хоол, хүнс	19,515,531.00	17,927,217.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,543,100.00	37,574,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	4,680,000.00
210604	Урсгал засвар	17,543,100.00	32,894,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,500,000.00	16,696,900.00

210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	16,696,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,649,038.00</b>	<b>27,958,947.06</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,927,500.00	26,533,317.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	91,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	39,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	30,000.00
210807	Газрын төлбөр	248,613.00	113,430.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	30,925.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,011,498.54</b>	<b>140,632,633.86</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,835,500.00	19,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,175,998.54	121,532,633.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,376,018.15</b>	<b>57,391,587.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,332,000.00</b>	<b>54,712,562.56</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,460,562.56
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,332,000.00	15,252,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>44,018.15</b>	<b>2,679,025.40</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,018.15	2,679,025.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>530,252,545.38</b>	<b>-45,346,475.25</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,352,176.72</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,352,176.72	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)</b>	<b>-4,352,176.72</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>525,900,368.66</b>	<b>-45,346,475.25</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>905,845,313.29</b>	<b>1,227,561,270.46</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>33,332,000.00</b>	<b>56,519,355.48</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>33,332,000.00</b>	<b>56,519,355.48</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>33,332,000.00</b>	<b>56,519,355.48</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,332,000.00	56,519,355.48
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>872,513,313.29</b>	<b>1,171,041,914.98</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>26,820,000.00</b>	<b>34,473,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,820,000.00	34,473,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>845,693,313.29</b>	<b>1,136,568,614.98</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	845,693,313.29	1,136,568,614.98
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>908,393,269.31</b>	<b>1,232,110,048.17</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>908,393,269.31</b>	<b>1,232,110,048.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>877,017,251.16</b>	<b>1,174,718,460.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>589,356,521.68</b>	<b>766,576,182.02</b>
210101	Үндсэн цалин	269,733,493.85	357,451,852.27
210102	Нэмэгдэл	257,863,132.01	341,997,044.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,426,181.82	26,582,545.45
210104	Урамшуулал	48,333,714.00	40,544,740.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	70,582,441.13	86,671,046.50
210201	Тэтгэврийн даатгал	48,742,449.55	60,373,007.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,687,549.36	7,046,537.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,866,314.52	3,830,340.06
210204	Ажилгүйдлийн даатгал	2,640,269.62	3,075,922.07
210205	Эрүүл мэндийн даатгал	10,645,858.08	12,345,240.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,075,981.85	23,794,274.60
210301	Гэрэл, цахилгаан	1,855,981.85	2,094,274.60
210302	Түлш, халаалт	16,720,000.00	19,900,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	64,173,304.50	96,911,007.01
210401	Бичиг хэрэг	2,907,790.00	14,156,920.00
210402	Тээвэр, шатахуун	36,720,814.50	45,305,797.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,070,000.00	4,235,489.41
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,833,700.00	17,469,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,641,000.00	15,743,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	89,248,554.00	87,848,003.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,482,034.00	56,933,260.02
210502	Хоол, хүнс	22,016,520.00	17,294,043.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,750,000.00	13,620,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,026,100.00	45,951,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,483,000.00	10,103,500.00
210604	Урсгал засвар	17,543,100.00	35,848,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,500,000.00	17,521,900.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	17,521,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,290,848.00	30,344,447.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,012,500.00	27,193,317.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	91,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	39,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	30,000.00
210807	Газрын төлбөр	248,613.00	113,430.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,587,735.00	1,725,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,763,500.00	19,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,763,500.00	19,100,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,376,018.15</b>	<b>57,391,587.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,332,000.00	54,712,562.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,460,562.56
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,332,000.00	15,252,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	44,018.15	2,679,025.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,018.15	2,679,025.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-2,547,956.02</b>	<b>-4,548,777.71</b>
		<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>40,034,000.00</b>	<b>45,319,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,034,000.00</b>	<b>45,319,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	40,034,000.00	45,319,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,034,000.00	45,319,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>-40,034,000.00</b>	<b>-45,319,000.00</b>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>00.00</b>	<b>00.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-42,581,956.02	-49,867,777.71
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	92,470,233.73	49,888,277.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,888,277.71	20,500.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	288,330,820.00	124,054,979.22	88,488,185.82	500,873,985.04
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	525,900,368.66	525,900,368.66
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>614,388,554.48</b>	1,026,774,353.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,090,392.84	1,090,392.84
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>615,478,947.32</b>	1,027,864,746.54
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,346,475.25	-45,346,475.25
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>570,132,472.07</b>	982,518,271.29

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,426,791,500.00</b>	<b>1,193,087,970.46</b>	<b>233,703,529.54</b>	<b>83.62</b>
12	Татварын бус орлого	1,426,791,500.00	1,193,087,970.46	233,703,529.54	83.62
120	Нийтлэг татварын бус орлого	66,156,000.00	56,519,355.48	9,636,644.52	85.43
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	66,156,000.00	56,519,355.48	9,636,644.52	85.43
122	Тусламжийн орлого	1,360,635,500.00	1,136,568,614.98	224,066,885.02	83.53
122001	Хандив тусламж /дотоод/	1,360,635,500.00	1,136,568,614.98	224,066,885.02	83.53
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,475,044,900.00</b>	<b>1,242,955,748.17</b>	<b>232,089,151.83</b>	<b>84.27</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,475,044,900.00	1,242,955,748.17	232,089,151.83	84.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,408,888,900.00	1,188,243,185.61	220,645,714.39	84.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>861,105,200.00</b>	<b>766,576,182.02</b>	<b>94,529,017.98</b>	<b>89.02</b>
210101	Үндсэн цалин	356,159,800.00	357,451,852.27	-1,292,052.27	100.36
210102	Нэмэгдэл	395,591,000.00	341,997,044.30	53,593,955.70	86.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,547,300.00	26,582,545.45	13,964,754.55	65.56
210104	Урамшуулал	68,807,100.00	40,544,740.00	28,262,360.00	58.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>102,466,900.00</b>	<b>86,671,046.50</b>	<b>15,795,853.50</b>	<b>84.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,004,800.00	60,373,007.00	8,631,793.00	87.49

210202	Тэтгэмжийн даатгал	8,365,500.00	7,046,537.19	1,318,962.81	84.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,932,800.00	3,830,340.06	1,102,459.94	77.65
210204	Ажилгүйдлийн даатгал	4,032,800.00	3,075,922.07	956,877.93	76.27
210205	Эрүүл мэндийн даатгал	16,131,000.00	12,345,240.18	3,785,759.82	76.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	105,903,400.00	99,411,007.01	6,492,392.99	93.87
210401	Бичиг хэрэг	19,900,000.00	14,156,920.00	5,743,080.00	71.14
210402	Тээвэр, шатахуун	43,393,200.00	45,305,797.60	-1,912,597.60	104.41
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,500,000.00	4,235,489.41	1,264,510.59	77.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,469,100.00	17,469,100.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,641,100.00	18,243,700.00	1,397,400.00	92.89
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	156,396,800.00	95,128,003.02	61,268,796.98	60.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,596,800.00	64,213,260.02	52,383,539.98	55.07
210502	Хоол, хүнс	19,900,000.00	17,294,043.00	2,605,957.00	86.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,900,000.00	13,620,700.00	6,279,300.00	68.45
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	111,021,000.00	72,690,600.00	38,330,400.00	65.47
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,300,000.00	19,695,000.00	28,605,000.00	40.78
210602	Тавилга	15,000,000.00	15,044,000.00	-44,000.00	100.29
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,900,000.00	10,103,500.00	9,796,500.00	50.77
210604	Урсгал засвар	27,821,000.00	27,848,100.00	-27,100.00	100.10
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17,521,900.00	17,521,900.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	17,521,900.00	17,521,900.00	00.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,573,700.00	30,344,447.06	4,229,252.94	87.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,998,800.00	27,193,317.06	2,805,482.94	90.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,152,000.00	348,000.00	76.80
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	91,000.00	409,000.00	18.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	39,200.00	250,800.00	13.52
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	30,000.00	136,000.00	18.07
210807	Газрын төлбөр	300,000.00	113,430.00	186,570.00	37.81
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,818,900.00	1,725,500.00	93,400.00	94.87
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19900000.00	19900000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,900,000.00	19,900,000.00	00.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	66156000.00	54712562.56	11443437.44	82.70
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	66,156,000.00	54,712,562.56	11,443,437.44	82.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,904,000.00	39,460,562.56	11,443,437.44	77.52
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,252,000.00	15,252,000.00	00.00	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-48,253,400.00	-49,867,777.71		

9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,253,400.00	49,867,777.71		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	48,253,400.00	49,867,777.71		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	49,888,277.71		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,500.00		

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>34,473,300.00</b>	<b>31,794,274.60</b>	<b>2,679,025.40</b>	<b>92.23</b>
12	Татварын бус орлого	34,473,300.00	31,794,274.60	2,679,025.40	92.23
122	Тусламжийн орлого	34,473,300.00	31,794,274.60	2,679,025.40	92.23
122005	Төсвөөс санхүүжих	34,473,300.00	31,794,274.60	2,679,025.40	92.23
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,473,300.00</b>	<b>31,794,274.60</b>	<b>2,679,025.40</b>	<b>92.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,473,300.00</b>	<b>31,794,274.60</b>	<b>2,679,025.40</b>	<b>92.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,473,300.00</b>	<b>31,794,274.60</b>	<b>2,679,025.40</b>	<b>92.23</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,473,300.00</b>	<b>23,794,274.60</b>	<b>2,679,025.40</b>	<b>89.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,773,300.00	2,094,274.60	2,679,025.40	43.87
210302	Түлш, халаалт	19,900,000.00	19,900,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.00
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	-		
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 198,382.1 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс, 166,438.1 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 31,944.0 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгч, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага, худалдан авах ажиллагаатай холбоотой хариуцлага тооцох 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

**3.1 Залруулсан алдаа**

1. Байдлын тайлангийн өглөг, тодруулгын дүн 8,040.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
2. Санхүүгийн байдлын тайлангийн баланс тэнцээгүй, 20.5 мянган төгрөгөөр зөрүүтэй толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
3. Мөнгөн гүйлгээний тайланг 54,733.1 мянган төгрөгийн зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

4. Байдлын тайлангийн эхний үлдэгдэл нь өнгөрсөн жилийн аудит хийсэн тайлангийн үлдэгдлээс 1,090.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
5. Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материал, үндсэн хөрөнгийг тус тусад нь дансанд бүртгээгүй нийлүүлж 97,886.1 мянган төгрөгөөр толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитаар залруулсан.
6. ЭМДС-аас санхүүжих санхүүжилтийн дүнг 1,786.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
7. Үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материалын дүн тодруулгын дүнгээс 223.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
8. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 2,658.5 мянган төгрөгийн зөрүүтэй бэлтгэж ирүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
9. Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан маягтаар тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй "толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй ба аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн шинээр нэвтэрч буй цахим системд тайланг шивж, шинэчилсэн загвараар бэлтгэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 31,944.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 15,682.5 мянган төгрөгөөс 16,261.5 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### **3.2. Албан шаардлага**

1. Шилэн дансны цахим хуудсанд 20 мэдээлэл оруулаагүй, 12 мэдээлэл хугацаа хоцроосон, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой шийдвэр болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг зэрэг заавал мэдээлэх мэдээллийг "оруулах мэдээлэл" байхгүй гэж буруу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтад "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.3 заалтад "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
2. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлахыг даалгасан өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтыг цахимаар зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд

худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 заалтад “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул тус эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилтийг аудитын дүгнэлт гаргаснаас хойш 1 сарын дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг Ханх сумын Засаг даргад даалгасан болно.

### **3.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт 1:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй 35 нэр төрлийн 142,520.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Тэг үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн бүртгэлд тусгах

##### Илрүүлэлт 2:

Программ хангамжийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012 онд орлогод авч байсан, цаашид ашиглах боломжгүй 15,000.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий эмнэлгийн цахим программ бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалтад “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Ашиглахгүй олон жил болсон программ хангамжийг данснаас хасах арга хэмжээг авах.

##### Илрүүлэлт 3:

Ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программыг данснаас хассан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,”-ыг бүртгэнэ гэж заасантай нийцэхгүй, “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Ашиглаж байгаа программ хангамжийг нягтлан бодох бүртгэлд тусгах

#### Илрүүлэлт 4:

Бараа материалын бүртгэлд өмнөх оны үлдэгдлээс зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл 749.1 мянган төгрөгийн эм бүртгэлтэй байгаа нь эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар бүртгээгүйг харуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 заалт “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг мөрдөж ажиллах, эмийн үлдэгдэлд тавих хяналтыг сайжруулах

### **2. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт 1:

Тайлант жилд төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн 31,194.9 мянган төгрөгийн 9 гүйлгээг хийсэн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах

#### Илрүүлэлт 2:

Тайлант жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг гаргаж, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт бэлтгэн ирүүлж байх

### **3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим системд оруулахдаа Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй байгаа нь Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.6 дахь заалтад “Захиалагч төрийн байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан баталж, санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн

дотор холбогдох дээд шатны байгууллагад төлөвлөгөөг цахим системээр илгээнэ: “ гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны аргыг сонгохдоо шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлах

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруу лаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байдлын тайлангийн өглөг, тодруулгын дүн зөрүүтэй тайлагнасан	1	8,040.1			1	8,040.1	1	8,040.1		
Санхүүгийн байдлын тайлангийн баланс тэнцээгүй	1	20.5			1	20.5	1	20.5		
Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй бэлтгэсэн	1	54,733.1			1	54,733.1	1	54,733.1		
Байдлын тайлангийн эхний үлдэгдэл нь өнгөрсөн жилийн аудит хийсэн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй	1	1,090.3			1	1,090.3	1	1,090.3		
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материал, үндсэн хөрөнгийг тус тусад нь дансанд бүртгээгүй нийлүүлж 1 дансаар бүртгэсэн	1	97,886.1			1	97,886.1	1	97,886.1		
ЭМДС-аас санхүүжих санхүүжилтийн дүнг зөрүүтэй тайлагнасан нь	1	1,786.3			1	1,786.3	1	1,786.3		
Үнэ төлбөргүй хүлээж авсан бараа материалын дүн тодруулгын дүнгээс зөрүүтэй	1	223.2			1	223.2	1	223.2		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэж ирүүлсэн	1	2,658.5			1	2,658.5	1	2,658.5		
Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан маягтаар тайланг бэлтгэж ирүүлээгүй	1	-	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>166,438.1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>166,438.1</b>	<b>9</b>	<b>166,438.1</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй 35 нэр төрлийн 142,520.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-					1	-
Цаашид ашиглах боломжгүй, 15,000.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий эмнэлгийн цахим программыг бүртгэлээс хасаагүй.	1	-					1	-
Бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдаагүй	1	749.1					1	749.1
Тайлант жилд төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн	1	31,194.9					1	31,194.9
Байгууллагын нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа программыг данс, бүртгэлд тусгаагүй	1	-					1	-
Тайлант жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй	1	-					1	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>31,944.0</b>					<b>7</b>	<b>31,944.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд мэдээллүүдийг оруулаагүй, хугацаа хоцроосон, оруулбал зохих мэдээллийг оруулах мэдээлэл байхгүй гэж хадгалсан.	1	-					1	-
Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>					<b>2</b>	<b>-</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		